




## I. Шинэ ажлын байранд 190 хүн зуучлагдлаа

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 5 сарын мэдээгээр нийт 248 ажлын байрны захиалга ирснээс 190 хүн ажлын байранд зуучлагджээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 15 хүнээр буурчээ. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 93 буюу 48.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажилд зуучилсан иргэдийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар




Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд боловсролын салбарт 13.7 хувь, уул уурхай олборлох үйлдвэрийн салбарт 13.2 хувь, хүний эрүүл мэнд болон нийгмийн халамжийн салбарт 2.1 хувь, төрийн удирдлага болон удирдлагын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт тус бүр 3.7 хувь, мэдээлэл холбооны салбарт 2.6 хувь, хөдөө аж ахуй салбарт 24.7 хувь, цахилгаан эрчим хүчний салбарт 3.7 хувь, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагааны салбарт тус бүр 1.1 хувь, үйлчилгээний бусад салбарт 27.4 хувь нь зуучлагджээ.



## II. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 46.5 хувиар буурчээ

2022 оны 5 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 303 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.5 хувиар буурсан байна. Нийт бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 49.8 хувь буюу 151 нь эмэгтэйчүүд байна.

Ажил хайгч иргэд, жил бүрийн 5 сарын байдлаар





## АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ирсэн нээлттэй ажлын байрны зарын дагуу 5 сарын байдлаар байнгын болон түр ажлын байранд 195 иргэнийг зуучлаад байна.

Зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харуулбал:

- Уул уурхайн салбарт-26
- ХАА-н салбар-47
- Бөөний болон жижиглэн худалдаа-6
- Мэдээлэл холбоо-5
- Санхүүгийн даатгалын үйлчилгээ-3
- Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаанд -10
- Боловсрол -26
- Барилга-6
- Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн чиглэлээр - 4
- Үйлчилгээний бусад үйл ажиллагаанд-52
- Урлаг үзвэр үйлчилгээний үйл ажиллагаанд-3
- Цахилгаан хий , уур агааржуулалтын хангамж-7
- Хүн хөлсөөр ажиллуулах өрхийн үйл ажиллагаа-2иргэн тус тус зуучлагдаж, ажлын байраар хангагдсан байна.



[dundgovi.hudulmur-halamj.gov.mn](mailto:dundgovi.hudulmur-halamj.gov.mn)



7059-2109

